

*цахим шуудан: lkhagvaemgen.b@ulaanbaatar.edu.mn

THE RELATIONSHIP BETWEEN STUDENT STRESS AND SOCIO-PSYCHOLOGICAL FACTORS

**email: lkhagvaemgen.b@ulaanbaatar.edu.mn*

Abstract

Introduction: University students encounter multiple academic, psychosocial, and environmental stressors during their transition to higher education. Nursing students may be particularly vulnerable because of concurrent academic and clinical demands. **Objective:** To identify the relationships among perceived stress, social support, and psychological anxiety among nursing students.

Methods: A cross-sectional quantitative study was conducted among first- to fourth-year nursing students at the International University of Ulaanbaatar. After excluding 16 incomplete questionnaires, 119 valid responses were analyzed using descriptive statistics, reliability testing, and correlation analysis in SPSS version 26.

Participants had a mean age of 22.39 ± 5.60 years, and 86.6% were female. The mean item scores were 3.15 ± 0.40 for perceived stress, 4.11 ± 0.78 for social support, and 2.35 ± 0.39 for total anxiety. Perceived stress was positively correlated with total anxiety ($r = .310$, $p = .001$), personal anxiety ($r = .307$, $p = .001$), and situational anxiety ($r = .261$, $p = .004$), and negatively correlated with age ($r = -.213$, $p = .020$). Social support was not significantly correlated with perceived stress ($r = .015$, $p = .872$) but was negatively correlated with total anxiety ($r = -.253$, $p = .005$) and personal anxiety ($r = -.334$, $p < .001$).

Conclusion: Students' perceived stress was associated with anxiety. Higher social support was related to lower anxiety, although a direct relationship between social support and perceived stress was not observed in this sample.

Key words: student stress; social support; anxiety; nursing students; cross-sectional study

Үндэслэл

Их, дээд сургуульд элсэн суралцах үе нь өсвөр наснаас насанд хүрэх шилжилтийн үе буюу бие физиологи, сэтгэл зүй болон нийгмийн орчны олон өөрчлөлттэй тулгарч, шинэ орчинд дасан зохицох шаардлагатай болдог¹. Энэхүү шилжилтийн онцлог нь оюутны бие даасан байдал, өөрийгөө үнэлэх үнэлэмж, академик хариуцлага болон харилцааны ур чадварт шинэ сорилт үүсгэдэг. Стресс нь тухайн хүний хүрээлэн буй орчин, шаардлага, нөөц бололцоог хэрхэн үнэлж, түүнд сэтгэлзүйн болон физиологийн түвшинд хэрхэн хариу үйлдэл үзүүлж байгаатай холбоотой ойлголт юм². Энэ үе нь хүүхдээс насанд хүрэгч болох хамгийн төвөгтэй үе бөгөөд өөрийгөө том хүн мэтээр мэдэрч эхэлдэг³. Энэ үед насанд хүрэгчид, нийгмийн зүгээс буруу хандах хандлага, харилцааны үр дагавар нь сөргөөр нөлөөлдөг. Тухайлбал сурах үйл ажиллагааны сонирхол буурах, дуулгаваргүй болох эсвэл хэт дуулгавартай болдог байна^{4,5}. Сувилахуйн оюутнуудын хувьд онолын мэдлэг эзэмших, эмнэлзүйн ур чадвар хөгжүүлэх, өвчтөнтэй харилцах, багш болон эмнэлгийн ажилтнуудын үнэлгээнд дасан зохицох зэрэг онцлог шаардлагаас шалтгаалан стресс нэмэгдэх боломжтой.

Оюутны стрессийн гол эх үүсвэрд нь хичээлийн ачаалал, шалгалт, шинэ орчин, санхүүгийн бэрхшээл, гэр бүлээс хол байх, нойр болон хооллолтын хэв маягийн өөрчлөлт, нийгмийн харилцаа зэрэг олон хүчин зүйл багтдаг⁶. Мөн стресс үүсэх хүчин зүйлүүдэд хүмүүс хоорондын харилцаа, хувь хүний онцлог, оюуны ачаалал болон хүрээлэн буй орчны хүчин зүйлс нөлөөлдөг бөгөөд амьдрах орчны өөрчлөлт, ганцаардал, унтах хэв маяг алдагдах, шинэ үүрэг хариуцлага, санхүүгийн бэрхшээл, эрүүл мэндийн асуудал зэрэг нь гол эх үүсвэр болдог⁷. Стрессээс шалтгаалан хоол боловсруулах систем амрах цагт хүнд хоол идэх, буруу хооллох зэргээс ходоодны өвчинд өртөх, ходоодны шарх үүсэх, хичээл, ажил хөдөлмөр хийх сонирхолгүй болох, нойр муудах зэрэг бие физиологид илрэх өөрчлөлтүүд нь үргэлжилбэл мэдрэлийн гаралтай өвчлөлийг үүсгэх үндэс болдог⁸.

Сүүлийн үеийн судалгаагаар их сургуулийн орчинд

дасан зохицох явц дахь стресс нь оюутнуудын сэтгэл зүйн тогтвортой байдал, сургалтын амжилтад шууд нөлөөлдөг болохыг онцолсон байна⁹. Мөн сувилахуйн оюутнуудын дунд хийсэн судалгаагаар нийгмийн дэмжлэг болон сэтгэл зүйн уян хатан байдал нь стрессийг бууруулж, сургалтын орчинд амжилттай дасан зохицоход чухал нөлөө үзүүлдэг болохыг тогтоожээ¹⁰. Иймд сувилахуйн оюутнуудын дунд тэдний стресст нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлон судалж суралцах явцад нь анхаарал хандуулан ажилласнаар цаашид нийгэмд хүлээн зөвшөөрөгдөхүйц мэргэжилтэн бэлдэхэд ач холбогдолтой гэж энэхүү судалгааг хийлээ.

Судалгааны зорилго: Оюутны стресс, нийгмийн дэмжлэг болон сэтгэлзүйн түгшүүрийн хоорондын хамаарлыг тодорхойлох.

Зорилтууд: Судалгааны ажлын зорилгын хүрээнд дараах зорилтыг тавилаа. Үүнд:

1. Оюутны стрессийн түвшинг тодорхойлох
2. Оюутны нийгмийн дэмжлэг болон сэтгэлзүйн түгшүүрийн байдлыг тодорхойлох
3. Оюутны стресс, нийгмийн дэмжлэг, сэтгэлзүйн түгшүүрийн хоорондын хамаарлыг тодорхойлох

Судалгааны арга зүй

Энэхүү судалгааг хөндлөн огтлолын нэг агшингийн тоон судалгааны загвараар гүйцэтгэсэн. Судалгааг Олон Улсын Улаанбаатарын Их Сургуулийн Сувилахуйн хөтөлбөрийн 1–4 дүгээр дамжааны оюутнуудын дунд явуулсан. Судалгаанд хамруулах шалгуурт: (1) тухайн хөтөлбөрийн 1–4 дүгээр дамжаанд суралцаж байх, (2) судалгаанд сайн дурын үндсэн дээр оролцохыг зөвшөөрөх, (3) асуумжийг бүрэн бөглөх гэсэн нөхцөлийг оруулсан. Хасах шалгуурт дутуу бөглөсөн асуумж болон судалгаанаас татгалзсан тохиолдлыг хамруулсан.

Түүвэрлэлт ба түүврийн хэмжээ

Судалгааны эх олонлогийг Олон Улсын Улаанбаатарын Их Сургуулийн Сувилахуйн бакалаврын хөтөлбөрт хамрагдан суралцаж буй нийт 150 оюутан гэж тодорхойлов. Түүврийн хэмжээг Yamane (1967)-ийн томъёогоор 95%-ийн итгэх түвшин, 5%-ийн түүврийн алдаатайгаар тооцоолсон.

Ийнхүү эх олонлог $N = 150$, түүврийн алдаа $e = 0.05$ гэж Yamane-ийн томъёогоор тооцоолоход эх

олонлогийг төлөөлж чадахуйц түүврийн тоо 109 байлаа.

$$n = \frac{N}{1+N(e)^2} = \frac{150}{1+150(e)^2} = 109$$

Тиймээс бид уг судалгааны түүврийн эрсдлийг 20 (22 асуумж) хувиар тооцоолон 131 асуумжийн цахим хэлбэрээр тараан мэдээллийг цуглуулсан ба 119 оюутан бүрэн хариулт өгсөн бөгөөд эдгээр өгөгдлийг эцсийн шинжилгээнд ашигласан ба судалгааны хүчинтэй түүврийн хэмжээ $n = 119$ байсан нь тараасан асуумжийн 79.3% байсан тул хангалттай түүвэр гэж үзсэн.

Судалгааны хэрэглэгдэхүүн

Мэдээллийг бүтэцлэгдсэн цахим асуумжаар цуглуулсан ба уг багц асуумж нь ерөнхий мэдээлэл, стресс, нийгмийн дэмжлэг болон сэтгэлзүйн түгшүүрийг үнэлэх хэсгүүдээс бүрдсэн.

Ерөнхий мэдээлэл: нас, хүйс, суралцаж буй курс зэрэг мэдээллийг агуулсан

- Стрессийг тодорхойлохдоо Perceived Stress Scale, PSS-14 сандарт аргачлалыг ашигласан. Асуумжийн нийт болон дундаж оноог тооцсон. Оноо өндөр байх тусам стрессийн түвшин өндөр гэж тайлбарлана.
- Нийгмийн дэмжлэгийг тодорхойлохдоо Солонгосын нийгмийн дэмжлэгийг тодорхойлох асуумж (Korean Social Support Questionnaire, KSSQ)-ийн 32 асуултыг ашигласан. Уг асуумжийн хариултыг мөн 1–5 онооны Ликертийн хэмжүүрээр үнэлж, дундаж оноог тооцсон. Оноо өндөр байх тусам оролцогчийн хүлээн авч буй нийгмийн дэмжлэг сайн гэж үзсэн. Нийгмийн дэмжлэгийн түвшинг 1.00–2.33 бол бага, 2.34–3.67 бол дунд, 3.68–5.00 бол өндөр түвшин гэж ангилан тайлбарласан.
- Сэтгэлзүйн түгшүүрийг үнэлэхдээ нөхцөл байдлын болон бие хүний түгшүүрийг тодорхойлох стандарт асуумжийг ашигласан. Асуумжийн оноог дундаж үзүүлэлтээр тооцож, 1–5 онооны Ликертийн хэмжүүрийн дагуу тайлбарласан. Дундаж оноо өндөр байх тусам сэтгэлзүйн түгшүүрийн түвшин өндөр гэж үзсэн бөгөөд 1.00–2.33 оноог бага, 2.34–3.67 оноог дунд, 3.68–5.00 оноог өндөр түвшин гэж ангилсан.

- Сэтгэлзүйн түгшүүрийн үнэлэхдээ Ю. Л. Ханины шинэчлэн боловсруулсан нөхцөл байдлын болон бие хүний түгшүүрийг үнэлэх 40 асуулт бүхий арга зүйг ашигласан. 1.5-аас бага оноог бага, 1.5–1.9-ийг дундаас доош, 2.0–2.9-ийг дунд, 3.0–3.4-ийг өндөр, 3.5–4.0-ийг маш өндөр түгшүүр гэж тайлбарласан.

Аргачлалын найдвартай байдал

Судалгаанд ашигласан хэмжүүрүүдийн дотоод нийцлийг Кронбахын α коэффициентоор үнэлсэн. PSS-14 асуумжийн $\alpha = .70$, нийгмийн дэмжлэгийн асуумжийн $\alpha = .98$, түгшүүрийн асуумжийн $\alpha = .89$ байсан тул дотоод нийцэл хүлээн зөвшөөрөхүйцээс маш сайн түвшинд байна гэж үзсэн.

Мэдээлэл цуглуулах үйл явц

Судалгааны асуумжийг Google Forms хэлбэрээр түгээж, оролцогчид 15–20 минутын хугацаанд бөглөсөн. Судалгаанд оролцох нь сайн дурын үндсэн дээр хийгдсэн бөгөөд оролцогчийн мэдээллийг нууцлан боловсруулсан.

Мэдээллийн дүн шинжилгээ

Мэдээлэлд SPSS-26 программ ашиглан боловсруулалт хийсэн. Оролцогчдын ерөнхий шинжийг давтамж, хувь, дундаж, стандарт хазайлт, хамгийн бага ба хамгийн их утгаар илэрхийлэв. Хэмжүүрүүдийн дотоод нийцлийг Кронбахын α коэффициентоор үнэлсэн. Стресс, нийгмийн дэмжлэг, түгшүүр болон насны хоорондын хамаарлыг Пирсоны хамаарлын коэффициентээр тооцсон. $p < .05$ утгыг статистикийн ач холбогдолтой гэж үзэв.

Судалгааны үр дүн

Table 1. General characteristics of participants

(N=119)

General characteristics of participants	Category	N(%) Mean±SD	Range	F(t)	P
Age		22.39±5.60	18-53	0.40541	0.03716
Sex	Male	16 (13.4)			
	Female	103(86.6)			
Year of study	First year	25 (21.0)		0.554	0.646
	Second year	25 (21.0)			
	Third year	37 (31.1)			
	Fourth year	32 (26.9)			

Судалгаанд нийт 119 оюутны хүчинтэй өгөгдлийг шинжилгээнд ашигласан. Оролцогчдын дундаж нас 22.39±5.60 жил, насны хүрээ 18–53 байв. Хүйсийн хувьд 103 (86.6%) нь эмэгтэй, 16 (13.4%) нь эрэгтэй байв. Курсээр авч үзвэл 1 дүгээр дамжааны 25 (21.0%), 2 дугаар дамжааны 25 (21.0%), 3 дугаар дамжааны 37 (31.1%), 4 дүгээр дамжааны 32 (26.9%) оюутан хамрагдсан.

Үзүүлэлт тус бүрийн статистик ялгааг нийт стресстэй нь харьцуулахад ($F=0.554$, $p=0.646$) байсан ба хүйсийн хувьд статистикийн ач холбогдолтой ялгаатай үр дүн илрээгүй. Харин насны хувьд статистикийн ач холбогдолтой ялгаа ажиглагдсан ($t=0.40541$, $p=0.03$). Энэ нь нас бага байх тусам стрессийн түвшингийн ялгаа байж болохыг харуулж байна. (Table 1)

Table 2. Student stress, social support, and anxiety indicators

(N=119)

Category	Mean±SD	Range	Description
Total Stress	3.15±0.40	2.4-4.64	Average
Total Social support	4.11±0.78	1.06-5.00	Relatively good
Total anxiety	2.35±0.39	1.33-3.25	Average
Situational anxiety	2.31±0.42	1.30-3.30	Average
Personal anxiety	2.40±0.43	1.35-3.85	Average

Оюутнуудын стрессийн нэг асуумжийн дундаж оноо 3.15±0.40, нийгмийн дэмжлэгийн дундаж оноо 4.11±0.78 байв. Нийт түгшүүрийн дундаж оноо 2.35±0.39 байсан бөгөөд Ханины

арга зүйн ангиллаар дунд түвшний түгшүүрт хамаарч байна. Нөхцөл байдлын түгшүүр 2.31±0.42, бие хүний түгшүүр 2.40±0.43 байсан нь мөн дунд түвшинд байна. (Table 2)

Table 3. The relationship between stress, social support, and anxiety

(N=119)

Category	1	2	3	4	5	6
1. Age	1					
2. Total Anxiety	-.141 (.125)	1				

3. Total Support	.021 (.824)	-.253** (.005)	1			
4. Personal anxiety	-.145 (.114)	.914** (<.001)	-.334** (<.001)	1		
5. Situational anxiety	-.114 (.218)	.918** (<.001)	-.132 (.153)	.677** (<.001)	1	
6. Total Stress	-.213* (.020)	.310** (.001)	.015 (.872)	.307** (.001)	.261** (.004)	1

*p<.05; **p<.01.

Хамаарлын шинжилгээгээр стресс нь настай сул сөрөг хамааралтай байлаа ($r=-.213$, $p=.020$). Өөрөөр хэлбэл нас нэмэгдэх тусам стрессийн оноо бага байх хандлага ажиглагдсан боловч хамаарлын хүч сул байна. Стресс нь нийт түгшүүр ($r=.310$, $p=.001$), бие хүний түгшүүр ($r=.307$, $p=.001$), нөхцөл байдлын түгшүүртэй ($r=.261$, $p=.004$) статистикийн ач холбогдолтой эерэг хамааралтай байв. Энэ нь түгшүүрийн оноо өндөр байх тусам стрессийн оноо өндөр байх хандлагатайг харуулж байна. Харин нийгмийн дэмжлэг нь стрессийн оноотой статистикийн ач холбогдолтой шууд хамааралгүй байв ($r=.015$, $p=.872$). Нийгмийн дэмжлэг нийт түгшүүр ($r=-.253$, $p=.005$) болон бие хүний түгшүүртэй ($r=-.334$, $p<.001$) сөрөг хамааралтай байсан нь дэмжлэг өндөр байх тусам түгшүүр бага байх боломжтой юм. (Table 3)

Хэлцэмж

Энэхүү судалгаагаар ОУУБИС-ийн Сувилахуйн хөтөлбөрийн 1–4 дүгээр дамжааны оюутнуудын стресс, нийгмийн дэмжлэг болон сэтгэлзүйн түгшүүрийн хоорондын хамаарлыг тодорхойлов. Үр дүнгээс харахад оюутнуудын стрессийн дундаж оноо харьцангуй өндөр, харин нийт түгшүүр, нөхцөл байдлын түгшүүр, бие хүний түгшүүр дунд түвшинд байна. Энэ нь их сургуулийн шилжилтийн үе болон сувилахуйн сургалтын онцлог шаардлага оюутны сэтгэлзүйн ачааллыг нэмэгдүүлэх боломжтойг харуулж байна.

Өмнөх олон улсын судалгаанд анагаахын болон сувилахуйн чиглэлийн оюутнуудын стресс академик ачаалал, шалгалт, клиник дадлага, суралцах арга барил, гэр бүл болон санхүүгийн асуудалтай холбоотой болохыг тогтоосон (Gupta et al., 2015; Langtree et al., 2018). Мөн хичээлийн цаг урт, сурах арга барил муу, гэр бүлийн эрүүл

мэндийн байдал, гэр бүлийн санхүүгийн асуудал, сурах бичгийн мөнгө хүрэлцэхгүй байгаа нь ихээхэн дарамт стресс үүсгэж байсан бол бидний судалгааны үр дүнд нийгмийн дэмжлэг харьцангуй сайн боловч, оюутнууд сэтгэл зүйн түгшүүрээс шалтгаалж стресс үүсгэх нь их байна гэсэн ялгаатай үр дүнг харуулж байна. (Langtree et al., 2018; Stallman, 2010). Түүнчлэн академик стресс нь түгшүүрийг статистикийн ач холбогдолтойгоор нэмэгдүүлдэг ($\beta=0.558$, $p<0.001$) бөгөөд түгшүүр нь цаашлаад оюутны туйлдад болон сурлагын амжилтад сөргөөр нөлөөлдөг болохыг тогтоосон нь манай судалгааны үр дүнтэй нийцэж байна. (Ishdorj et al., 2026)

Иймээс оюутны стресс нэмэгдэхийн хэрээр сэтгэлзүйн түгшүүрийн түвшин өсдөг болохыг манай болон өмнөх судалгааны үр дүнгүүд харилцан баталж байна.

Судалгааны хамгийн чухал үр дүн нь стресс ба сэтгэлзүйн түгшүүрийн хооронд статистикийн ач холбогдолтой эерэг хамаарал илэрсэн явдал юм. Нийт түгшүүр, бие хүний түгшүүр болон нөхцөл байдлын түгшүүр өндөр байх тусам стрессийн оноо өндөр байсан. Энэ үр дүн нь стрессийг бууруулах хөтөлбөрийг зөвхөн сургалтын ачааллын зохицуулалтаар хязгаарлахгүй, харин түгшүүрийг таних, даван туулах ур чадвар, зөвлөгөө, үе тэнгийн болон багшийн дэмжлэг, сэтгэлзүйн боловсролтой хамтатган хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна. Нийгмийн дэмжлэгийн дундаж оноо харьцангуй сайн байсан боловч нийт стрессийн оноотой шууд ач холбогдолтой хамаарал илрээгүй. Иймээс “нийгмийн дэмжлэг стрессийг бууруулдаг” гэж энэхүү өгөгдөл дээр шууд дүгнэх нь зохимжгүй. Харин нийгмийн дэмжлэг нийт түгшүүр болон бие хүний түгшүүртэй сөрөг хамааралтай байсан

нь нийгмийн дэмжлэг нь стрессийн шууд бус хамгаалах хүчин зүйл байж болохыг таамаглуулах боломжтой. Үүнийг баталгаажуулахын тулд цаашид олон хүчин зүйлийн регресс, урт хугацааны судалгааны загвар ашиглах шаардлагатай юм.

Судалгааны ажлын хязгаарлагдмал байдал

- Судалгааг нэг их сургуулийн нэг хөтөлбөрийн оюутнуудын дунд явуулсан тул үр дүнг Монгол Улсын бүх их, дээд сургуулийн оюутнуудад шууд ерөнхийлөн хэрэглэхэд болгоомжтой хандах шаардлагатай.
- Судалгаа нь нэг агшингийн загвартай тул стресс, нийгмийн дэмжлэг, түгшүүрийн хооронд шалтгаан-үр дагаврын холбоо тогтоох боломжгүй; зөвхөн тухайн үеийн хамаарлыг тодорхойлсон.
- Энэхүү судалгаанд зөвхөн хоёр хувьсагчийн хамаарлыг үнэлсэн тул стрессийг тайлбарлах олон хүчин зүйлийн нэгдсэн загвар, хувьсагчдын хоорондын хамаарал болон зохицуулах нөлөөг тодорхойлоогүй болно.

Дүгнэлт

1. Судалгаанд хамрагдсан сувилахуйн оюутнуудын стрессийн дундаж оноо харьцангуй өндөр түвшинд, нийт болон дэд түвшний түгшүүр дунд түвшинд байна.
4. Оюутны стресс нь нийт түгшүүр, бие хүний түгшүүр болон нөхцөл байдлын түгшүүртэй статистикийн ач холбогдолтой эерэг хамааралтай байна.
5. Нийгмийн дэмжлэг нь стрессийн нийт оноотой шууд хамааралгүй боловч нийт түгшүүр болон бие хүний түгшүүртэй сөрөг хамааралтай байна.
6. Иймд оюутны стрессийг бууруулах арга хэмжээг түгшүүрийг эрт илрүүлэх, зөвлөгөө өгөх, үе тэнгийн болон багшийн дэмжлэгийг нэмэгдүүлэх, суралцах арга барил болон өөрийгөө зохицуулах ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэх шаардлагатай.

Санал зөвлөмж

- ОУУБИС-ийн Сувилахуйн оюутнуудад стресс, түгшүүрийн богино скринингийг улирал бүр зохион байгуулах
- 1–2 дугаар дамжааны оюутнуудад дасан

зохицох, суралцах арга барил, цаг төлөвлөлт, шалгалтын түгшүүрийг даван туулах сургалт хэрэгжүүлэх

- Багш-зөвлөх, үе тэнгийн менторшип болон нийгмийн дэмжлэгийн тогтолцоог хөтөлбөрийн түвшинд бэхжүүлэх
- Дараагийн судалгаанд стрессийн эх үүсвэр, академик амжилт, клиник дадлагын орчин, нойр, санхүүгийн дарамт зэрэг хувьсагчийг нэмж, олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээ хийх

Ном зүй

1. Erikson EH. Identity: Youth and Crisis. W.W. Norton & Company; 1968.
2. Lazarus RS, Folkman S. Stress, Appraisal, and Coping. Springer Publishing Company; 1984.
3. Мягмар О. Хүний хөгжлийн сэтгэл зүйн лекц. Улаанбаатар; 2000.
4. Оюундалай Н, Балжинням Б, Бэх Ч. Нийгмийн сэтгэл судлал. Улаанбаатар; 2017.
5. Feldman RS. Development Across the Life Span. 8th ed. Pearson Education; 2017.
6. Gupta S, Choudhury S. Factors causing stress among students of a medical college in Kolkata, India. Educ Health (Abingdon). 2015;28(1):92-95.
7. Pascoe MC, Hetrick SE, Parker AG. The impact of stress on students in secondary school and higher education. Int J Adolesc Youth. 2020;25(1):104-112. doi:10.1080/02673843.2019.1596823
8. Зэвгээ Т. Хүний эмгэг физиологи. Улаанбаатар; 2016.
9. Zhao S, Zhang Y, Yu C, Xie M, Chen P, Lin D. Trajectories of perceived stress among students in transition to college: Mindset antecedents and adjustment outcomes. J Youth Adolesc. 2023;52:1873-1886. doi:10.1007/s10964-023-01817-0
10. Park SJ, Jung YS. Factors influencing college life stress on college life adaptation in nursing students: Sequential mediating effects of psychological flexibility and social support. Korean J Youth Stud. 2023;30(10):493-518.
11. Langtree EM, Razak A, Haskins L. Factors causing stress among first-year students attending a nursing college in KwaZulu-Natal, South Africa.

- 47